



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 98

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон ашиглалтын шаардлага хангахгүй, засвар хийхэд эдийн засгийн хувьд ашиггүй 13 нэрийн нийт 7,460,646.00 /долоон сая дөрвөн зуун жаран мянга зургаан зуун дөчин зургаан/ төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын ерөнхий захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Отгонбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001317

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн
.....⁹⁸ дугаар тогтоолын хавсралт



Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын үндсэн
хөрөнгөд бүртгэлтэй актлаж данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Даралтын аппарат	2003	1	180,900.00	180,900.00
2	Универсал халаагуур	2012	1	190,000.00	190,000.00
3	Хөргөгч престиж	2009	1	429,000.00	429,000.00
4	Хөргөх шкаф	2007	1	1,159,950.00	1,159,950.00
5	Цахилгаан пийшин	1993	1	18,090.00	18,090.00
6	Принтер	2015	1	719,900.00	719,900.00
7	Барилгын шат	2011	1	319,000.00	319,000.00
8	Матрас	2008	40	54,000.00	2,160,000.00
9	Сандаал /түшлэггүй	2012	1	23,400.00	23,400.00
10	Тавиур	1978	4	2,713.50	10,854.00
11	Хар сандал	2006	40	26,714.00	1,068,560.00
12	Хувцасны шкаф	1987	6	86,832.00	520,992.00
13	Шат угсардаг	2009	6	110,000.00	660,000.00
	Нийт дүн		104		7,460,646.00 /долоон сая дөрвөн зуун жаран мянга зургаан зуун дөчин зургаан/